

“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр

№ 2025/01

Улаанбаатар хот

“СОР” ХК–ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 11 цаг 05 минутанд “СОР” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 11:05 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг Гүйцэтгэх захирал Д.Жанрай даргалав.

Тооллогын комисс-д Д.Сүхээ, Н.Баярмаа нар тус тус ажиллав.

Хурлын ирц:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 712459 ширхэг хувьцаа эзэмшигч 8 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох 891 388 ширхэг хувьцааны 79,9 % болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д.Сүхээ хурал даргалагчид танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1	"БЛЮ СКАЙ КАШЕМИР" ХХК	420671
2	Титан инвест ХХК/О.Хулан/	151000
3	"Монгол даатгал" ХХК/О.Хулан/	78445
4	С.Мягмарсүрэн	20967
5	С.Пүрэвжав	41304
6	Ж.Энхтунгалаг	50
7	Г.Ганзориг	20
8	М.Шигшээ	2

Хурлын дарга Д.Жанрай хурлын ирц, тооллогын комиссын тогтоолыг танилцуулан ээлжит хурлыг нээж, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав

Хэлэлцэх асуудал:

1. **Хэлэлцэх асуудал-1:** 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх

Мэдээлэл өгөх: Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ;

2. **Хэлэлцэх асуудал-2:** Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;

3. **Хэлэлцэх асуудал-3:** ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв батлах;

Хэлэлцэх асуудал-1:

“СОР” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Д.Жанрай

Асуулт, санал хариулт:

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн

“СОР”ХК-ийн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх асуудлыг хэлэлцүүлэх талаар бичгээр гаргасан хүсэлтийн талаар болон Компанийн 2025 оны ашигт ажиллагааны талаар асуулт тавив.

Д.Жанрай хөрөнгийн дахин үнэлгээний асуудал нь Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах тул ТУЗ-ийн ээлжит хуралд асуудлыг оруулж хариу өгнө Мөн тэрээр “СОР”ХК-нь түрээсийн орлогоор санхүүждэг хэдий ч улс орны нийгэм эдийн засаг, мөн түрээслэгч “БЛЮ СКАЙ КАШЕМИР”ХХК-ийн үйл ажиллагаа, санхүү эдийн засаг, санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаатай уялдан 2025 онд бодит зорилт дэвшүүлэхэд тулгамдаад байгаа тул өнгөрсөн жилийн түвшинтэй ойролцоо байхаар төлөвлөлж байгаа хэмээн мэдэгдэв.

Хурал даргалагч 1-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 712459 ш хувьцаа /100%/

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

СОР” ХК-ийн 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж батлах.

Мэдээлэл өгөх : Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Компани нь 2024 онд алдагдалтай ажилласан тул ТУЗ-өөс “Ногдол ашиг хуваарилахгүй талаар” шийдвэр гарсныг Хурал даргалагч Д.Жанрай уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудал-2: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилох;

Хурал даргалагч Д.Жанрай ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан шийдвэрийг, тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураасан дүнг Тооллогын комиссын дарга Д.Сүхээ танилцуулав.

Санал хураалтын куммулятив аргаар тооцсон дүн:

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Д.Нямхүү	С.Б.Громов	Д.Жанрай	Л.Таня	Н.Ханбулаг	Пономаревна Светлана	А.Санчирмаа	Ж.Эрдэнэтуяа	Д.Дашгомбо
"БЛЮ СКАЙ"ХХК	420671	420671	420671	420671	420671	420671	420671	420671	420671	420671
Титан инвест ХХК	151000		271800		271800		271800	271800	271800	
"Монгол даатгал"ХХК	78445		78445							
С.Мягмарсүрэн	20967	0	0	188703	0	0	0	0	0	0
С.Пүрэвжав	41304	0	0	371736	0	0	0	0	0	0
Ж.Энхтунгалаг	50	50	50	50	50	50	50	50	50	50
Г.Ганзориг	20	20		40	40	20		20	20	20
М.Шигшээ	2	2	2	2	2	2	2	2	2	2
нийт	712459	420743	770968	981202	692563	420743	692523	692543	692543	420743

ШИЙДВЭР:

1. “СОР” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр дараах нэр бүхий хүмүүсийг томилох:

ЕРДИЙН гишүүнээр:

1. Д.Нямхүү
2. С.Б.Громов
3. Д.Жанрай
4. Л.Таня
5. Н.Ханбулаг
6. И.Дариймаа

ХАРААТ БУС гишүүнээр

1. А.Санчирмаа
2. Ж.Эрдэнэтуяа
3. Д.Дашгомбо

Хэлэлцэх асуудал- 3:

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

ТУЗ-ийн 2025 оны төсвийн талаар **Д.Жанрай** дараах тайлбар мэдээлэл хийв.

“Сор”ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг идэвх санаачилга, үр дүнтэй ажиллуулах хүрээнд тодорхой урамшуулал олгож байхаар шийдсэн ба түүнчлэн үйл ажиллагаанд шаардагдах тодорхой төсвийг тооцож нийтдээ **8 200 250 ,0 /найман сая хоёр зуун мянга хоёр зуун тавин мянган/** төгрөгөнд багтаасан болохыг танилцуулав.

Хурал даргалагч 3-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 8 хувьцаа эзэмшигч буюу 712459 ш хувьцаа ш хувьцаа эзэмшигч

Татгалзсан: 0


Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

1. Компанийн 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг **8 200 250,0 /найман сая хоёр зуун мянга хоёр зуун тавин мянган/төгрөгөөр** батлах


Хурлаар өөр асуудал хэлэлцээгүй тул 14.00 цагт хурлын үйл ажиллагаа дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:




Н.Баярмаа -Тооллогын комиссын гишүүн

Танилцсан:


Хурал даргалагч:..........Д.Жанрай

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид :


"БЛЮ СКАЙ КАШЕМИР" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

..........Д.Ганчимэг

Титан инвест ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

..........О.Хулан

"Монгол даатгал" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

..........О.Хулан

